ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 02 №26/09 Улаанбаатар хот

“Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

“Дархан зочид буудал” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60,1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.2, Санхүүгийн хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Дархан зочид буудал” ХК-ийн 2026 оны ээлжит бус хурал 2026 оны 12 сарын 12-ны өдөр 14:00 цагт Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 2-р хороо Центр пойнт төв “Бурхан халдун групп”-ын байранд хуралдуулсугай.
2. “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
   - ТУЗ-ийн гишүүдийг томилох.
   - Компанийн хэлбэрийн өөрчлөлтийг хэлэлцэж батлах,
   - Компанийн дүрмийг шинэчлэн батлах,
   - Бусад
3. “Дархан зочид буудал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг **Хавсралт-01**, хурлын зарыг **Хавсралт-02,** хурлын дэгийг **Хавсралт-03** хуралтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт-04**, хуралд санал авах саналын хуудасны загварыг **Хавсралт 05**-д тус тус баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2026 оны 11 сарын 04-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус хүргүүлж, олон нийтэд 11 дүгээр сарын 07-нд зарласугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнээр байгуулсугай.

   Үүнд:

   Дарга: П.Чимгээ

   Гишүүд: С.Мөнхдөш, Ю.Төвшинтөгс

Тооллогын комиссын даргаар Т.Оюунцэцэг,

7. Тус тогтоолын хавсралтаар батлсан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг бэлэн болгож 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
8. Компанийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх давтан зарыг өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2026 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр дахин мэдээлэхийг ээлжит бус хурал зохион байгуулах комиссын дарга П.Чимгээд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ..... П. АЛИМАА

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ ХК
ТТГ5656 2024802